



САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ИХ СУРГУУЛЬ
ӨДРИЙН ХӨТӨЛБӨР



БАНКНЫ АШИГТ АЖИЛЛАГААНД НӨЛӨӨЛӨГЧ ХҮЧИН ЗҮЙЛС

Гүйцэтгэсэн: Г.Булганхүү, Т.Чингэс,
М.Оргил-Эрдэнэ, Б.Мөнхшүр
Удирдсан багш: Ц.Батсүх (Ph.D)

2019 он

АГУУЛГА

- Удиртгал
- Судлагдсан байдал
- Тоон өгөгдөл, аргачлал
- Судалгааны таамаглал
- Шинжилгээний хэсэг
 - *Өгөгдлийн шинжилгээ*
 - *Эконометрикийн шинжилгээ*
- Дүгнэлт

АГУУЛГА

- УДИРТГАЛ
- Судлагдсан байдал
- Тоон өгөгдөл, аргачлал
- Судалгааны таамаглал
- Шинжилгээний хэсэг
 - *Өгөгдлийн шинжилгээ*
 - *Эконометрикийн шинжилгээ*
- Дүгнэлт

Асуудал

- Тухайн улсын эдийн засгийн амин судас нь санхүүгийн салбар байдаг бол санхүүгийн салбарын үндсэн тулгуур нь банкны салбарын хөгжил байдаг. Иймд улс орнууд санхүүгийн системийн тогтвортой хөгжлийг хангах зорилгоор түүнийг ашигт ажиллагаанд нөлөөлөгч хүчин зүйсийг тодорхойлох нь нэн чухал асуудал юм. Нөгөөтэйгүүр сүүлийн 20 жилийн турш хөгжиж буй болон шилжилтийн эдийн засагтай орнуудын банкны системд гадаадын хөрөнгө оруулалт (ГХО)-ын хэмжээ эрс өссөнтэй холбогдуулан түүний нөлөөг онцлон авч үзэх нь чухал юм.

Зорилго

- Энэхүү судалгааны зорилго нь банкны системийн ашигт ажиллагааг илэрхийлдэг активын өгөөж (ROA)-д микро болон макро түвшний тайлбарлагч хувьсагчид хэрхэн нөлөөлж байгааг тогтоох
- Тухайн арилжааны банк гадаадын хөрөнгө оруулалттай эсэхээс хамаарч ашигт ажиллагаа нь хэр ялгаатай байдаг эсэхийг тогтоох явдал юм.

Таамаглал

- Арилжааны банкны харьцаа үзүүлэлтүүдээр илэрхийлсэн дотоод хувьсагчид нь банкны ашигт ажиллагааг илэрхийлэгч гол хувьсагчид мөн.
- Мөн улс орны эдийн засгийн нөхцөл байдлыг илэрхийлсэн ДНБ гэх мэт хувьсагчид дам нөлөөгөөр банкны ашигт ажиллагаанд тодорхой хэмжээнд нөлөөлдөг байж болох юм.
- Гадаадын хөрөнгө оруулалттай банк нь гадаадын хөрөнгө оруулалтгүй банктай харьцуулахад банкны салбарын үр ашгийг дээшлүүлж, инноваци явуулж, хяналт зохицуулалт бий болгох, цаашлаад удирдлага менежментийн хувьд илүү үр ашигтай ажилладаг учир ашигт ажиллагаа өндөр байх боломжтой.

АГУУЛГА

- Удиртгал
- **СУДЛАГДСАН БАЙДАЛ**
- Тоон өгөгдөл, аргачлал
- Судалгааны таамаглал
- Шинжилгээний хэсэг
 - *Өгөгдлийн шинжилгээ*
 - *Эконометрикийн шинжилгээ*
- Дүгнэлт

Банкны ашигт ажиллагаанд нөлөөлөгч хүчин зүйлс

Судлаач	Зорилго	Өгөгдөл, аргазүй	Үр дүн
Haslem /1969/	АНУ-н ХНС-д бүртгэлтэй нийт арилжааны банкуудын ашигт ажиллагаанд нөлөөлөгч хүчин зүйлсийг тодорхойлох.	ХНС-д бүртгэлтэй нийт арилжааны банкуудын санхүүгийн харьцаа үзүүлэлтүүд, болон макро хувьсагчдыг ашиглан статистик шинжилгээ хийсэн.	<ul style="list-style-type: none"> • Банкны харьцаа үзүүлэлтүүд нь банкны ашигт ажиллагаатай эерэг хамааралтай байна • БДНБ-ийн өсөлт банкны секторын ашигт ажиллагаатай статистик ач холбогдлыг хувьд хамааралгүй
Guru (2002)	Малайзын банкны ашигт ажиллагааг тодорхойлогч хүчин зүйлсийг тодорхойлох.	Малайзын 17 арилжааны банкны 1986-1995 оны 10 жилийн тоон өгөгдөлд тулгуурлан панел үнэлгээ хийсэн.	<ul style="list-style-type: none"> • Үр ашигтай зардлын удирдлага нь банкны ашигт байдлыг тодорхойлогч хамгийн чухал хүчин зүйл • Хүүний түвшин ашигт байдалд сөрөгөөр нөлөөлдөг • Инфляцийн түвшин болон ашигт байдлын хооронд тогтвортой эерэг хамаарал байдаг
Ben Naceur ба Omran (2008)	Ойрхи Дорнод болон Хойд Африкийн орнуудын арилжааны банкуудын хүүний зөрүү болон ашигт байдалд банкны хууль эрх зүйн орчин, төвлөрөл, санхүүгийн болон институцийн хөгжил хэрхэн нөлөөлж байгааг тодорхойлох.	Ойрхи Дорнод болон Хойд Африкийн орнуудын 1989-2005 оны хоорондох арилжааны банкуудын өгөгдлийг ашиглан стресс тест үнэлсэн.	<ul style="list-style-type: none"> • Өөрийн хөрөнгийн хүрэлцээ, зээлийн эрсдэл зэрэг банкны үзүүлэлтүүд цэвэр хүүний зөрүү, ашигт байдал, зардлын үр ашигт эерэг нөлөөтэй байдаг
Sufian ба Habibullah (2009)	Хятад улсын банкны системийн шинэчлэлийн дараах үе буюу 2000-2005 оны хооронд ашигт байдалд нөлөөлөгч хүчин зүйлсийг тодорхойлох	Хятад улсад үйл ажиллагаа явуулж буй нийт арилжааны банкуудын 2000-2005 оны тоон өгөгдлийг ашиглан панел үнэлгээ хийсэн.	Хөрвөх чадвар, зээлийн эрсдэл болон өөрийн хөрөнгийн хүрэлцээ зэрэг үзүүлэлтүүд төрийн өмчит арилжааны банкуудын ашигт байдалд тогтвортой эерэг нөлөөг үзүүлдэг, харин үйл ажиллагааны зардал сөргөөр нөлөөлдөг

Банкны ашигт ажиллагаанд ГХО-ын үзүүлэх нөлөө

Судлаач	Зорилго	Өгөгдөл, аргазүй	Үр дүн
<p>П.Бонин, И.Хасан, П.Вачел (2004)</p>	<p>Шилжилтийн эдийн засагтай улсууд дээр банкны үйл ажиллагаа, үр ашигт байдал болон гадаадын хөрөнгө оруулалтын хоорондын хамаарлыг тодорхойлох.</p>	<p>Уг судалгааг нийт 11 шилжилтийн эдийн засагтай улс орнууд дээр 1996-2000 оны өгөгдөл дээр ажилласан ба нийт 225 банк, 856 ажиглалтын утга цуглуулж панел үнэлгээ хийсэн</p>	<ul style="list-style-type: none"> • Дотоодын банк дангаараа ажиллах нь банкны үр ашгийг хангаж чадахгүй байна, • Гадаадын хөрөнгө оруулалттай банкнууд илүү их хадгаламж татаж, илүү их зээл олгож чадвартай байдаг буюу илүү сайн санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг • Засгийн газрын эзэмшилд байгаа банк илүү бага зээл олгож, бага хадгаламж татах ба хүүгийн бус зардал илүү их гаргадаг • Банкны үр ашигт байдалд гадаадын хөрөнгө оруулагчид эерэг нөлөө үзүүлнэ
<p>Али (2005)</p>	<p>Лондон дахь гадаадын банк болон дотоодын банкны ашигт ажиллагааг тодорхойлогч хүчин зүйлс, ашигт ажиллагааны ялгааг харьцуулах.</p>	<p>Лондон дахь 36 арилжааны банкны 2004-2010 оны улирлын өгөгдлийг ашиглан регрессийн үнэлгээ хийсэн.</p>	<ul style="list-style-type: none"> • Гадаадын банк тухайн банкны эзэмшлээс үл хамааран дотоодын банкнаас илүү үр ашигтай ажилладаг • Гадаадын банкинд үзүүлэх макро эдийн засгийн хувьсагчдийн нөлөө дотоодын банктэй харьцуулахад бага байдаг
<p>С.Классенс, А.Демиргүк-Кунт, Г.Гуйзинг (1998)</p>	<p>Банкны зах зээлд гадаадын эзэмшил орж ирэх ямар нөлөөтэйг судлах.</p>	<p>Судалгааг нийт 80 улс дээр 1988-1995 оны өгөгдөл дээр хийсэн бөгөөд энэхүү судалгаа нь гадаадын банкнууд дотоодын банкнаас хэрхэн ялгарч үйл ажиллагаагаа явуулдгийг харуулахын тулд панел үнэлгээ хийсэн.</p>	<ul style="list-style-type: none"> • Гадаадын банк нэмэгдэх нь илүү банкны зах зээлийг өрсөлдөөнтэй болгодог ба дотоодын банкнуудыг илүү үр ашигтай ажиллах хөшүүргийг үүсгэдэг • Хөгжиж буй орнуудын хувьд гадаадын банк нь дотоодын банкнаас илүү өндөр хүүгийн хэмжээтэй, ашиг орлоготой ба татварын төлөлт ихтэй байдаг

АГУУЛГА

- Удиртгал
- Судлагдсан байдал
- **ТООН ӨГӨГДӨЛ, АРГАЧЛАЛ**
- Судалгааны таамаглал
- Шинжилгээний хэсэг
 - *Өгөгдлийн шинжилгээ*
 - *Эконометрикийн шинжилгээ*
- Дүгнэлт

ТООН ШИНЖИЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ

Өмнө нь хийгдэж байсан судалгааны ажлуудыг үндсэн хоёр бүлэгт хувааж болно:

1. Олон улсын түвшинд судалсан: Эдийн засгийн бүтэц нь ижил бүлэг улсын банкны системд микро болон макро хувьсагчид, ГХО хэрхэн нөлөөлж байгааг голлон судалдаг.
2. Тухайн нэг улсын хувьд судалсан: Сонгон авсан тухайн улсын банкны систем дэх микро болон макро хувьсагчид, ГХО-ын нөлөөллийг судалдаг.

ТООН ӨГӨГДӨЛ, АРГАЧЛАЛ

Энэхүү судалгаанд банкны дотоод буюу микро түвшний хувьсагчдыг Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа 9 банкны 2011-2016 онуудын санхүүгийн тайлан тэнцэл болон орлого зардлын жилийн тайланд үндэслэлээ

- **Ашигт байдлыг хэмжих хувьсагч** судалгааны ажлуудад түлхүү ашиглагдаж байгаа буюу активын өгөөжийг хамааран хувьсагчаар сонгож авлаа
- **Дотоод нөлөөлөгч хүчин зүйлс:** хэмжээг илэрхийлсэн үзүүлэлт \LNTA\, хөрвөх чадварын үзүүлэлт \LIQ/TA\, нийт хадгаламжийн хэмжээ \EQASS\, зардлын удирдлага \OVC/TA\, активийн бүтэц \NII/TA\, зээлийн эрсдэл \LLPTA\
- **Гадаад нөлөөлөгч хүчин зүйлс:** Тухайн оны БДНБ-ийн өсөлтийн хувь \RGDP_growth\, Гадаадын хөрөнгө оруулалтын дамми \FSI\

ТООН ӨГӨГДӨЛ, АРГАЧЛАЛ

$$y_{it} = \alpha'_{jt}X_{jt} + \beta'_{it}Y_{jt} + \varepsilon_{jt}$$

- j - тухайн банкыг илэрхийлэх индекс
- t - тухайн жилийг илэрхийлэх хугацааны индекс
- y_{it} - j -р банкны t -р жилийн активын өгөөж (ROA)
- X - нь банкны дотоод тайлбарлагч хувьсагчдыг илтгэх
- Y - нь гадаад буюу макро эдийн засгийн хувьсагчдыг илэрхийлэх үзүүлэлт болно.

ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН НӨЛӨӨГ ХЭРХЭН ТООЦОХ

А.Панел өгөгдлийн эконометрик шинжилгээ

Хятад улсын судлаачид Xiaoyan Huang, Yong Zeng нар ажилдаа зээлийн хэмжээнд гадаад банк орж ирсэнээрээ ямар нөлөө үзүүлэхийг судлахдаа дараах эконометрик загварыг ашигласан байна Xiaoyan Huang (2011). Үүнд:

$$L_{it} = \alpha + \beta * FB_t + \gamma_1 * FSI_i + \gamma_2 * Ownership_i + \gamma_3 * Bank\ characteristics_{it} + \gamma_4 * Macro_t + \mu_i + \varepsilon_{i,t}$$

Үүнд:

- L_{it} - t хугацаан дахь i – р банкны зээл
- FB_t - t хугацаан дахь гадаад банкны системд үзүүлэх нөлөө
- FSI_i - дотоодын банкны хоёр хэлбэрийн ялгааг илэрхийлсэн дамми
- $Ownership_i$ - i-р банк эзэмшлийн хэлбэр
- $Bank\ characteristics_{it}$ - i-р банкны эзэмшлийн хэлбэр
- $Macro_t$ - t – хугацааны макро эдийн засгийн үзүүлэлтүүд

Б.Панел өгөгдлийн эконометрик шинжилгээ

Claessens (2001) нарын судлаачид гадаадын банк нэвтэрсэнээр гадаад, дотоодын банкуудын цэвэр хүүний зөрүү, татвар төлөлт, ашигт ажиллагааны түвшин нь тухайн банкны эзэмшлийн байдал, банкны онцлогийг илэрхийлсэн харьцаа үзүүлэлтүүд болон улсынх нь макро үзүүлэлтүүдээс хэрхэн хамаарч байгааг судалсан. Регрессийн шинжилгээний загварын тавилыг авч үзье:

$$\Delta l_{ijt} = \alpha_0 + \beta_1 * \Delta FS_{jt} + \delta_{ij} * \Delta \beta_{ijt} + \gamma_j * \Delta X_{jt} + \varepsilon_{ijt}$$

Үүнд:

- Δl_{ijt} - t хугацаан дахь j – р орны i – р банк таварын өмнөх ашиг болон хүүний цэвэр орлого, хүүний бус орлого, нэмэглт зардал, зээлийн алдагдал зэрэг эндоген үзүүлэлт
- ΔFS_{jt} - t хугацаан дахь j -р орны i – р банкны системд гадаад банкны системд эзлэх хувь
- $\Delta \beta_{ijt}$ - t хугацаан дахь j -р орны i – р банкны хяналтын үзүүлэлтүүд
- ΔX_{jt} - t хугацаан дахь j -р орны макро эдийн засгийн үзүүлэлтүүд
- Энэхүү регресзагварын параметруудийг Fitch компаний BankScore өгөгдлийн санг ашиглан Diff and diff аргаар, тогтмол нөлөөний загвар үнэлсэн байна.

АГУУЛГА

- Удиртгал
- Судлагдсан байдал
- Тоон өгөгдөл, аргачлал
- **СУДАЛГААНЫ ТААМАГЛАЛ**
- Шинжилгээний хэсэг
 - *Өгөгдлийн шинжилгээ*
 - *Эконометрикийн шинжилгээ*
- Дүгнэлт

СУДАЛГААНЫ ТААМАГЛАЛ

Хувьсагчид	Таамаглаж буй ТЭМДЭГЛЭЛ
<i>Хамаарагч хувьсагч /ROA/</i>	
<i>Дотоод нөлөөлөгч хувьсагчид</i>	
Хэмжээг илэрхийлсэн үзүүлэлт	+/-
Хөрвөх чадварын үзүүлэлт	+/-
Нийт хадгаламжийн хэмжээ	+
Зардлын удирдлага	-
Активын бүтэц	+
Зээлийн эрсдэл	-
<i>Гадаад нөлөөлөгч хувьсагчид</i>	
Тухайн оны бодит ДНБ-ий өсөлтийн хувь.	+
Эздийн өмчийн 50-с дээш хувь гадаадын эзэмшилд бол 1, бусад тохиолдолд 0	+/-

Хүснэгт 1: Ашигт байдлыг тодорхойлох хувьсагчид, түүнд нөлөөлөх таамаглал

АГУУЛГА

- Удиртгал
- Судлагдсан байдал
- Тоон өгөгдөл, аргачлал
- Судалгааны таамаглал
- **ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭСЭГ**
 - *ӨГӨГДЛИЙН ШИНЖИЛГЭЭ*
 - *ЭКОНОМЕТРИКИЙН ШИНЖИЛГЭЭ*
- Дүгнэлт

ХУВЬСАГЧДЫН ТОДОРХОЙЛОГЧ СТАТИСТИКУУД

	LNTA	LIQTA	NIITA	OVCTA	EQASS	LLPTA	GDPGRO
Дундаж	2.87	0.16	0.01	-0.03	0.09	0.01	0.09
Медиан	3.06	0.14	0.01	-0.03	0.08	0.01	0.09
Хамгийн их утга	3.74	0.45	0.21	0.01	0.30	0.11	0.16
Хамгийн бага утга	1.33	0.04	-0.02	-0.07	0.04	0.00	0.02

ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭСЭГ

	LNTA	LIQTA	NIITA	OVCTA	EQASS	LLPTA	GDPGRO
LN/TA	1.00						
LIQ/TA	0.23	1.00					
NI/TA	-0.31	0.12	1.00				
OVC/TA	0.48	0.04	-0.33	1.00			
EQASS	-0.56	-0.02	0.69	-0.62	1.00		
LLP/TA	-0.41	-0.24	-0.09	-0.44	0.35	1.00	
GDPGROW	-0.14	0.09	-0.12	-0.04	-0.13	0.22	1.00

Хүснэгт 3 Тайлбарлагч хувьсагчдийн Спирмэний корреляцийн коэффициент

ҮНДСЭН ҮНЭЛГЭЭ

$$ROA_{jt} = 0.007 * LNTA_{jt} + 0.022 * \frac{LIQ}{TA} + 0.78 * \frac{NII}{TA_{jt}} + 0.05 * \frac{OVC}{TA_{jt}} +$$

(2.26) (1.2) (10.66) (0.39)

$$0.223 * EQASS_{jt} - 0.19 * \frac{LLP}{TA_{jt}} + 0.05 * FSI_{jt} + 0.08 * GDP_{gro} + \varepsilon_t$$

(3.13) (2.01) (1.54) (2.45)

$$R^2 = 0.898 \quad AR^2 = 0.88$$

Эконометрик үнэлгээний статистик ач холбогдол

Микро хувьсагчид	Магадлал	Нийт активын өгөөжид үзүүлэх нөлөө
Хэмжээг илэрхийлсэн үзүүлэлт	0.0286	+
Хөрвөх чадварын үзүүлэлт	0.2366	+
Активын бүтэц	0.000	+
Зардлын удирдлага	0.6956	+
Нийт хадгаламжийн хэмжээ	0.0031	+
Зээлийн эрсдэл	0.0514	-
Макро хувьсагчид		
БДНБ өсөлт	0.0183	+
Гадаадын хөрөнгө оруулалтын дамми	0.132	+

АГУУЛГА

- Удиртгал
- Судлагдсан байдал
- Тоон өгөгдөл, аргачлал
- Судалгааны таамаглал
- Шинжилгээний хэсэг
 - *Өгөгдлийн шинжилгээ*
 - *Эконометрикийн шинжилгээ*
- ДҮГНЭЛТ

ДУГНЭЛТ

- Судалгааны үр дүнд микро хувьсагчид буюу банкны санхүүгийн харьцаанууд ашигт ажиллагаанд тодорхой нөлөөллийг үзүүлдэг болох нь харагдлаа. Мөн гадаадын хөрөнгө оруулалтай банкууд дотоодын хөрөнгө оруулалттай банкуудтай харьцуулахад илүү ашигтай ажилладаг болох нь ажиглагддаг байна.
- Энэхүү судалгааны шинэлэг зүйл нь 1. Өгөгдлийн хувьд шинэчлэгдсэн бөгөөд орчин үеийн банкны ашигт ажиллагааг тодорхойлогч хувьсагчдыг тодорхойлохыг зорьсон. 2. Сүүлийн 20 жилийн турш хөгжиж буй болон шилжилтийн эдийн засагтай орнуудын банкны системд гадаадын хөрөнгө оруулалт (ГХО)-ын хэмжээ эрс өссөнтэй холбогдуулан түүний нөлөөг онцлон авч үзсэн зэрэг явдал юм.

Анхаарал хандуулсанд баярлалаа